

Эрдэмтний яриа

1219 онд Солонгост илгээсэн захидлыг би олж, хэвлүүлсэн

—"МНТ" судлалыг шинэ өндөрлөгт гаргав"

■ Д.ШАТАР

Балдандоржийн Сумъяабаатар 50 настай. Сүхбаатар аймгийн Хонгор сумын харьяат. Яс угсаа-дариганга. 1955-1960 онд БНАСАУ-ын их сургуульд суралцаж төгссөн. Шинжлэх ухааны байгууллагад 30 гаруй жил ажилласан. 1990-1996 онд Өмнөд Солонгосын Тангүг их сургуульд уригдан багшилж, эрдэм шинжилгээний ажил хийсэн. Эл сургуулийн дэд профессор цолтой.

Монгол түмний бүтээсэн дахин давтагдашгүй бүтээлийн нэг бол их хаадын үед бичигдсэн "Монголын нууц товчоо" хэмээх алдарт сулар билээ. Харамсалтай нь энэ хосгүй нандин бүтээлийн жинхэнэ монгол эх нь өдий болтол олдоогүй бөгөөд харин хятад хэл дээр хэвлэгдсэн хэд хэдэн "Нууц товчоо" байдаг байна. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Сумъяабаатар хятадын түүхч эрдэмтэн Е.Дэжуйн (1864-1927) 1908 онд хэвлүүлсэн 12 дэвтэр "Нууц товчоо"-ны хятад эхийг иш үндэс болгон баримталж тун сонирхолтой судалгаа хийж 3000 шахам хуудас бүтээл туурвисан нь олны анхаарлыг татаж байна. Саяхан энэхүү бүтээлийг туурвисны төлөө түүнд хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг олгов. Б.Сумъяабаатарын "Монголын нууц товчоо"-ны хэлбэр судлал" гэдэг бүтээлийг манай эрдэмтэн мэргэд өндөрөөр үнэлж дотоод, гадаадын судлаачдад асар их хэрэгтэй арвин хэрэглэгдэхүүн бэлдэж өгөв. Ирээдүйн залуу эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний ажлын аятай "будда" зэхлээ гэж үзэж байна.

"Монголын нууц товчоо"-г (МНТ) эрдэмтэд гол төлөв түүхэн сурвалжийн бичиг талаас судалдаг, хэл шинжээчид зонхилон үгийн утгыг нь тайлахыг завддаг бол Б.Сумъяабаатар бүр дотогш гүн орж үгийн үсийг нь судалж, үгийг үеийн түвшинд нарийвчлан авч үзсэн байна.

МНТ-г 500 гаруй хятад үсгээр галигласан гэж судлаачид тоймлодог бол Б.Сумъяабаатар 571 үсгээр галиглажээ хэмээн тооцоолон гаргаад, түүнийг нэг бүрчлэн жагсааж, үсэг тус бүрийн үгийн эхэн, дунд, адагт орсон байдлыг нэгд нэгэнгүй гаргаж ойллого тайлбар хийжээ. Тэгээд энэ бүхнийг цахим тооцоолуурт оруулж нангиад үсэг бүрт тоон дугаар өгсөн байна.

Үүнийг дэлхийн монгол судлалын хэнийх нь ч хүрээгүй байгаа түвшин, шинжлэх ухааны нээлт гэж үзсэн ч болно гэж эрдэмтэд нотолж байгаа юм. Үүнээс өмнө 1990 онд МНТ-ны 750 жилийн ойд зориулж Б.Сумъяабаатар МНТ-ны үсгийн галигаар хятад эх, латин галиг, нангиад дуудлагатай маш олон тайлбар, зүүлт бүхий ном бичсэн нь монголын хамгийн том номонд тооцогддог билээ. Ийнхүү Б.Сумъяабаатар бол МНТ судлалыг шинэ замд хөтөлж, шинэ өндөрлөгт гаргаж яваа судлаач эрдэмтэн юм.

Б.Сумъяабаатарын докторын зэрэг горилсон бүтээл нь МНТ-ны үсгийн сангийн үеийн бүтцийг бүхэлд нь бүрэн хамарчээ. Үүний өмнө эрдэмтэд МНТ-ны уламжлан ирсэн хувилбарууд дахь бичлэгийн зөрөөг гаргах оролдлого хийж байсан бол Б.Сумъяабаатар энэ удаа МНТ-ны нэг эхэд нэгэн монгол үгийг өөр өөрөөр галигласан эсэх асуудлыг дэвшүүлэн тавьж зохистойгоор тайлбарлаж чаджээ. Одоо

Б.Сумъяабаатар түүх, хэл шинжлэлийн холбогдолтой 50 орчим өгүүлэл бичиж нийтлүүлсэн. "XIII-XIV зууны үеийн Монгол, Солонгосын харилцааны бичгүүд", "Буриадын үгийн бичээс", "Монгол хэлний ойролцоо үгийн товч толь", "Өвөг монгол хэл бичгийн чухал дурсгал" гэх зэрэг бие даасан есөн ном, нэг сэдэвт зохиол туурвижээ. 1973 онд "Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд" гэдэг ганц сэдэвт бүтээлээрээ хэл бичгийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан. Энэ намар "Монголын нууц товчооны хэлбэр судлал" гэдэг хоёр ангит, дөрвөн бүлэгт бүтээлээрээ хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгааллаа.

мэргэжил нэгтэй нөхдийнх нь үнэлэлт дүгнэлтийг сонирхоё.

О.СҮХБААТАР. (Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд доктор):

-Сумъяабаатар бол ганц сэдэвт зохиол олныг бичсэн, их бүтээлч, уйгагүй хүн. МНТ-ны авиан зүйн хэлбэр судлалд анх удаа статистик арга хэрэглэж, бүх үгийг тооцон гаргаж, тухайн нэг үг хэдэн үсэг, үснээс бүтсэн, түүнийг хэрхэн олох түлхүүрийг гаргаж өгсөн. Манай эрдмийн зөвлөл түүний бүтээлийг шинжлэх ухааны өндөр түвшинд хийгдсэн, онол практикийн чухал ач холбогдолтой туурвил гэж үнэлсэн.

Л.БОЛД. (Хэл зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч):

-МНТ бол эрдэмтэн бүрийн чадал тэнхээг сорьдог түүхийн дурсгал. Дэлхийн том эрдэмтэд үүн дээр хүчээ үзэж байна. Сумъяабаатарын энэ ажил бол Монгол судлалын сонгодог хэлбэр, сонгодог арга олсон ажил. Талд ганцхан хайлаас ургадаггүй гэж Да багш хэлдэгсэн. Монголын хэл шинжлэлийнхний өтгөн ойн дундахь сүрлэг гацуурын нэг бол манай Сумъяабаатар мөн гэж хэлмээр байна.

Х.САМПИЛДЭНДЭВ. (Хэл зохиолын хүрээлэнгийн


захирал):

-Сумъяабаатар бол солонгос хэл төгс мэддэг, ханз үсэг уншдаг, дорно дахины гүнзгий боловсролтой хүн. Энэ ажлыг Сумъяабаатар шиг нямбай нягт, хийгүй хүн хийхээс өөр хүн хийхэд бэрхшээлтэй. Өөрөөр хэлбэл энэхүү нарийн чимхлүүр ажил эзнээ олсон... Ийнгэд Б.СУМЪЯАБААТАРТАЙ уулзаж цөөн асуулт тавьж харну авсан юм.

-Чингис хааны үеийн "Их засаг" хуулийн тасархайг таныг олсон гэж ярьдаг. Энэ яриа ортой юу?

-Энэ бол Европоос ч, манайхаас ч олдоогүй зүйл. Солонгос сурвалжаас би олж анх удаа олны хүртээл болгож хэвлүүлсэн. Аль XIII зууны үед бичигдсэн тэрхүү цаазын бичигт бусдын булш бунхан ухах тэнхөж дээрэмдэж болохгүй, эзлэгдсэн орны охид эмстэй хүч түрэмгийлэн гэрлэж болохгүй, аян дайны зам зуурын ой төгөл, цэцэг жимсийг сүйтгэж болохгүй гэсэн заалт байдаг нь сонирхол татдаг. Иймэрхүү хуульчлал XIII зуунд байтугай бүр хожим ч Европ дахинд, Азид байгаагүй юм билээ.

Бичиг үсэг, хууль эрхийн хувьд тэр үеийн монголчууд өндөр соёлтой байсныг энэ баримт гэрчилдэг.



-Монгол, Солонгосын ард түмнүүд ойролцоо нутаглаж нэг хэлтэн, нэг нутагтан байсан байх гэсэн таамаглал байдаг. Хэрэв тийм бол хэдийд холдож хөндийрсөн байж болох вэ?

-Монгол, Солонгос хэлний үгсийн сан, хэл зүйд хоорондоо адил төсөөтэй зүйл маш их. Жишээ нь Солонгос хэлний хуруу, чих, хэл, аав, ээж гэх мэтчилэнгийн гаднаас зээлдэггүй үгнүүд монгол хэлний тийм утгатай үгстэй тун төсөөтэй дуудагддаг. Төмрийн үеэс өмнө, барагцаалбал хүрлийн үед Монгол, Солонгос хоёр нутаг ус тусгаарлагдсан байж болох юм. Үүнээс өмнө бид нэг нутагтан, нэг хэлтэн байжээ гэдгийг үгүйсгэхэд хэцүү. Төв Азиас эрт дээр үед нүүсэн нүүдэлчдийн удам угсаа нь солонгосчууд байж болно. Солонгосын хад чулууны бичээст Халхын гол, Буйр нуурын тухай дурдаад тэнд өвөг дээдэс уулздаг байв гэж тэмдэглэсэн нь тааралддаг юм шүү.

-Монгол улс Солонгостой хэдүй үеэс албан ёсоор харилцаж эхэлсэн юм бол?

-Монгол, Солонгос хоёр 1215 оноос харьцаж эхэлжээ. 1219 онд тийшээ илгээсэн захидлыг би олж далаад онд хэвлүүлсэн. 1221 онд Монголоос илгээсэн захидалд бэх, бийр, бичгийн цаасны тоо хэмжээг заагаад тийм хэрэглэл яаралтай ирүүлэхийг солонгосын талд зарлиг болгосон байдаг. Бас 995 онд Солонгосоос бидний өвөг дээдэс болох Хятад улсын хэлийг сургахаар арван эрэгтэй хүүхэд явуулсан баримт бий. Өөрөөр хэлбэл 1000 жилийн өмнө тэднийх нааш нь оюутан илгээж байжээ. Харин монгол улс 1224 онд 40 гаруй хөвгүүнийг суралцуулахаар илгээжээ. Сурвалж бичигт тэмдэглэснээр XIII зууны үед монголын элч нарын дотор эмэгтэй хүн явж Солонгост хүрч байсан гэдэг. Энэ нь Өгөдэй хааны үед юм шиг байдаг. 1221 оны нэгэн захидалд пус тогтоодог, эмэгтэйчүүдийн өвчинд их сайн нөлөө үзүүлдэг гүргэм гэдэг эм илгээхийг зарлигджээ.

-Эртний олдвор дээр байсан үл мэдэгдэх нэгэн бичгийг таныг тайлж уншсан гэж сонссон. Энэ юун олдвор вэ?

-Тийм ээ. 1983 онд Булган

аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь Хүннүгийн булшнаас "алтан хүн" (хүний дүрс бүхий цэвэр алтан хуудас) гарсан. Ийм олдвор дэлхийд ганцхан ширхэг. Энэ бол зоос биш. Маш нимгэн цэвэр алтан ялтсан дээр хүний дүрс, бас нэгэн зүйл бичгэрхүү тэмдэглэгээ байдаг. Дээд хоёр өнцөгт нь нүхэлснийг бодвол ямар нэгэн хүн зүүж байсан биз. Энэ олдвор одоо улсын эрдэнэ-сийн санд хадгалагдаж байгаа.

Би тэгээд түүнийг хааны тамга буюу шаньюй тамга гэж тайлан уншсан. Одоо дэлхий дахины эрдэмтэд, судлаачид миний тайлбарыг хүлээн зөвшөөрч байх шиг байна. Эл үсэг, бичиг бол латин, грекийн соёлоос цаашилж, улмаар финик үсэгтэй холбогдож байгаа юм л даа. Энэхүү "алтан хүн"-ий дээрх бичээс нь Крит (Итали) арлаас олдсон Фестийн хүрдний бичээс, Харапшийн (Энэтхэг) чулуун тамгын бичээс, Атлантын далайн (Чили орчим) Пасха арал дээрх бичээсүүдтэй ерөнхийдөө тохирдог.

Тэгэхээр Хүннү нар нэн баялаг соёлтой, дэлхийн соёл иргэншилтэй өргөн хэлхээ холбоотой том гүрэн байжээ гэсэн дүгнэлтэд арга буюу хүргэдэг юм